



КОМПАНИЙН НИЙГМИЙН
ХАРИУЦЛАГЫН ТАЙЛАН
2014



ЭНЕРЖИ
РЕСУРС ХХК

АГУУЛГА

КОМПАНИЙН ТУХАЙ

Товч танилцуулга	06
Онцлох үйл явдал, бүтээн байгуулалт	06
Олон улсын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байдал	07

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Бодлого, чиг баримжаа	09
Компанийн засаглал	09
Оролцогч сонирхогч талуудын хамтын ажиллагаа	10
Өргөдөл, гомдол барагдуулах механизм	10

АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

Хүний нөөцийн удирдлага	11
Ажлын байр, тэгш боломж	11
Ажиллагсдын шилжилт хөдөлгөөн	12
Сургалт, хөгжил	12

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Татвар төлөлт	13
Орон нутгийн хөрөнгө оруулалт	13
Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	14

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлага, (БОХАБЭА)	18
Бодлого, чиг баримжаа	18
Суурь судалгаа	18
Газар ашиглалт, нөхөн сэргээлт	19
Биологийн төрөл зүйлийг дэмжих	20
Усны зохистой хэрэглээ	21
Агаарын чанар, тоосжилт	22
Хог хаягдлын менежмент	22
Хяналт, үнэлгээ	24

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Бодлого, чиг баримжаа	25
Гол үзүүлэлтүүд	25
Сургалт, зааварчилгаа	25

БИДНИЙ АМЖИЛТ



ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно





ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинг нэн тэргүүнд анхаарна.
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монголд хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг. Иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.
- Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг. Иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

КОМПАНИЙН ТУХАЙ

■ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс ХХК нь 2005 онд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай уул уурхайн компани бөгөөд нэмүү өртөг шингэсэн, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөн, Монгол Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилтэд өөрийн бодитой хувь нэмрийг оруулах зорилготойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Тус компани нь Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа Худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2,962 га талбай бүхий, 11952А ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Ухаа Худаг уурхайн үйл ажиллагаа 2009 оны 4-р сард эхэлсэн бөгөөд дэд бүтцийн хөгжил сул, алслагдсан бүс нутагт энэхүү төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийг цогцоор нь байгуулах шаардлагатай болсон.

Төвөөс алслагдмал говь нутагт монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, орон сууцны хороолол, сургууль цэцэрлэг зэрэг дэд бүтцийн томоохон барилга, байгууламжуудыг маш богино хугацаанд бүтээн байгуулсан тус уурхай нь эдүгээ дэлхийн жишигт нийцсэн, уул уурхайн цогцолбор болон хөгжиж байна.

Энержи Ресурс компани нь 2010 оны 10-р сард Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж,

Монголын үндэсний компаниудаас анх удаа олон улсын хөрөнгийн зах зээлд гарч, олон улсын зах зээл болон хөрөнгө оруулалтын банк, санхүүгийн байгууллагуудад танигдсан, нээлттэй хувьцаат компани бөгөөд тус компанийн 60 орчим хувийг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг. Ухаа Худаг уурхай нь Монголдоо анхдагч Нүүрс баяжуулах үйлдвэр болон дагалдах дэд бүтцийн шийдлүүдийг бүрэн цогцлоож, улс орныхоо уул уурхай, боловсруулах үйлдвэрлэлийн хөгжилд шинэ шат ахиулан, өмнийн уудам говьд их бүтээн байгуулалтыг өрнүүлж байна.

■ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ, БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ

Өнгөрч буй 2014 онд дан ганц уул уурхайн салбар гэлтгүй улс орны эдийн засгийн хувьд бүхэлдээ хямралтай, хүндхэн жил байсан боловч Энержи Ресурс компанийн зүгээс бүтээмжээ нэмэгдүүлэх, зардал бууруулах, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтад шилжих зэргээр дотоод нөөц боллоцоогоо дээд зэргээр дайчлан ажилласны дүнд өмнөө тавьсан зорилго, зорилтуудаа гүйцэд биелүүлж, 2014 онд нийт 74 тэрбум төгрөгийн орлогыг татвар, шимтгэл хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлжээ.

Тайлант онд дэд бүтцийн бүтээн байгуулалтын хүрээнд уурхайн Нүүрс баяжуулах үйлдвэр болон орон сууцны “Цэций” хорооллыг бүрэн ашиглалтанд оруулахад хөрөнгө оруулалтуудыг төвлөрүүлэн ажилласан.





Нүүрс баяжуулах үйлдвэр

Өнгөрөгч онд Нүүрс баяжуулах үйлдвэр болон уурхайн цогцолборын усан хангамжийн системийг өргөтгөх, дэд бүтцийг сайжруулах ажлыг амжилттай хэрэгжүүлснээр уурхайн дэд бүтцийн найдвартай ажиллагаа улам бүр дээшилж байна.

Нүүрс баяжуулах үйлдвэр нь жилдээ нийт 15 сая тонн нүүрс угааж баяжуулах хүчин чадалтай бөгөөд дэргэдээ Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэртэйгээр ажиллаж байна. Ингэснээр үйлдвэрийн усны хэмнэлтийг өмнөхөөс 60–70% нэмэгдүүлж, усны дахин ашиглалтыг 95% –д хүргэсэн. Мөн 2014 онд нүүрс баяжуулах үйлдвэрт олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн удирдлагын шинэ систем нэвтрүүлснээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна. Тодруулбал, үйлдвэрийн дотоод үйл ажиллагаанд “2F+2P” удирдлагын системийг нэвтрүүлснээр Нүүрс баяжуулах үйлдвэрийн жилийн нийт хүчин чадлыг 15 сая тонноос 18 сая тонн болгон нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Ийнхүү нүүрсийг угааж баяжуулснаар дотооддоо нэмүү өртгийг бий болгож, нүүрсний үнэ цэнийг өсгөн, монгол нүүрсний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж байна.

“Цэций” орон сууцны хороолол

2011 оноос эхлэн баригдсан орон сууцны “Цэций” хорооллын I–III ээлжийг ашиглалтанд оруулах ажлыг өнгөрөгч онд бүрэн дуусгаж, холбогдох тохижилт, үйлчилгээний ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд Цогтцэций суманд баригдсан “Цэций” хороололд өнөөдрийн байдлаар 560 гаруй айл төвхнөн амьдарч байгаа бөгөөд тус хороолол нь усан оргилуур, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэн зэргийг барьж байгуулснаараа оршин суугчдын тав тухтай амьдралын хэрэгцээ шаардлагыг хангахаас гадна усчин, эмнэлэг, гоо сайхан, халуун ус, супермаркет зэрэг ахуйн үйлчилгээний байгууламжуудыг цогцоор нь бүрдүүлсэн онцлогтой. Иж бүрэн тавилгатай, тохилог орон сууцнууд шинээр үүд хаалгаа нээснээр компанийн ажиллагсад болон сумын иргэдийн ая тухтай ажиллаж, амьдрах нөхцөл бүрэн хангагдаад зогсохгүй сумын нийгмийн

үйлчилгээний ачааллыг бууруулж, уурхай дагасан тогтвор суурьшил бий болж, хөдөөгөөс хотруу чиглэсэн урсгалыг сааруулахад бодитой хувь нэмэр оруулж байна.



■ ОЛОН УЛСЫН УДИРДЛАГЫН ТОГТОЛЦОО НЭВТРҮҮЛСЭН БАЙДАЛ

2F+2P менежментийн систем шинээр нэвтрүүлэв

2014 онд Ухаа Худаг дахь Нүүрс баяжуулах үйлдвэрт олон улсын шилдэг туршлагад суурилсан “2F+2P” удирдлагын системийг шинээр нэвтрүүллээ. Энэхүү системийг нэвтрүүлэхэд ямар нэгэн нэмэлт зардал огт шаардлагагүй бөгөөд зөвхөн одоо байгаа ажлын цаг, хуваарь, чиг үүрэг, менежментийн систем зэрэгт өөрчлөлт оруулах замаар үйлдвэрийн бүтээмж ба бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлсэн.

Тухайлбал осол, гэмтэл гарсан тухай бүр засвар хийж цаг алдахын оронд хуваарьт засваруудын цагийг нэмэгдүүлж, ажлын хуваарьтаа өөрчлөлт оруулсан. Мөн сул зогсолтыг багасгах, ээлжийн зохион байгуулалтыг өөрчлөх зэрэг алхмуудыг авч хэрэгжүүлснээр үйлдвэрийн жилийн хүчин чадлыг 15–аас 18 сая тонн болгон нэмэгдүүлэх боломжтой болсон. Хамгийн гол нь энэхүү системийг шинээр нэвтрүүлэхэд ямар нэгэн зардал шаардагдаагүй, мөн үйлдвэрийн тогтмол зардлыг огт нэмэгдүүлээгүйгээрээ онцлогтой.

Машин механизмын удирдлага, хяналтын систем нэвтрүүлээ

Уурхайн цаашдын өсөлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, тоон мэдээллийн удирдлага, мэдээ тайлагналтыг автоматжуулах, уурхайн техник тоног төхөөрөмжийн ажлын хуваарилалтыг зөв зохистой, бүтээмж өндөртэйгээр зохион байгуулах, машин тус бүрийн ажлын гүйцэтгэлийг нарийн нягт зохион байгуулж сайжруулах зорилготойгоор Fleet management системийг нэвтрүүлсэн.

Уурхайн эргэн тойронд байрлуулсан WiFi сүлжээг ашиглан машин механизм тус бүрийг сүлжээнд холбосноор орчин үеийн компьютерийн дэвшилтэт технологи, програм хангамжинд тулгуурлан машин бүрийн байршил, ажлын төлөв, гүйцэтгэлийг тухай бүр цаг алдалгүй хүлээн авч боловсруулж, шаардлагатай удирдлагаар ханган ажиллах нөхцөл бүрдсэн.

Уурхайн орчин дахь суурин ба хөдөлгөөнт 10 бааз станц дээр байрлуулсан сүлжээний дэд бүтцэд одоогийн байдлаар 160 орчин машиныг холбож, уг системийн тусламжтайгаар удирдаж байна.

Motorola Tetra тоон радио холбоо

Motorola Tetra тоон радио холбоо нь Ухаа Худаг уурхай орчимд орчин үеийн дэвшилтэт технологи бүхий тоон радио холбооны дэд бүтцийг бий болгож, түүний тусламжтайгаар байнгын болон аюул ослын үед ашиглагдах найдвартай харилцаа холбоог бий болгож байна. Энэхүү төслийн хүрээнд Ухаа Худагт 30–70 метр өндөр бүхий гурван ширхэг цамхаг, түүн дээр байрлуулсан радио холбооны сүлжээ, холбооны удирдлагын тоног төхөөрөмж, гар утас зэргийг суурилуулж, тохируулгын ажлууд хийгдсэн. Системийн хүчин чадлын хүрээнд 1,000 хүртэлх радио утсыг ашиглаж болохоос гадна мөн тооны сувгуудыг бий болгох боломжтой. Энэхүү тоон радио систем нь одоо



хэрэглэгдэж буй аналог радио станцтай холбогдон ажиллах боломжтойгоор хийгдсэн бөгөөд төслийн хүрээнд нийт 300 утсыг суурилуулаад байна.

Чанарын нэгдсэн төв лаборатори шинээр итгэмжлэгдэв

Ухаа Худаг уурхайд нүүрсний олборлолтоос эхлээд экспортын бүтээгдэхүүн бий болох хүртэл үйлдвэрлэлийн бүхий л шат дамжлага, түүнд шаардлагатай дэд бүтцийн найдвартай үйл ажиллагаа тун чухал. Эдгээр процессын чанарын хяналтыг хийж, стандартын шаардлага хангаж байгаа эсэхийг мэргэжлийн 50 гаруй боловсон хүчнээс бүрдсэн Чанарын нэгдсэн төв лаборатори хариуцан ажилладаг.

Энэхүү лаборатори нь 2012 онд Стандартчилал, Хэмжилзүйн Газрын шийдвэрээр MNS ISO/IEC 17025:2007 стандартын шаардлагад нийцсэн үндэсний итгэмжлэгдсэн лабораториор батламжлагдан бөгөөд 2014 оны долдугаар сард магадлан итгэмжлэлээ дахин баталгаажуулан гурван жилээр сунгуулж, улмаар зөвхөн өөрийн компанийн төдийгүй бусад байгууллагын дээж, сорьцыг шинжлэх, дүгнэлт гаргах эрхтэй болсон.



КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

■ БОДЛОГО, ЧИГ БАРИМЖАА

Энержи Ресурс компанийн хувьд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурийг бий болгохыг зорин ажилладаг.

Энэ хүрээнд “ISO26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж” болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн компанийн нийгмийн хариуцлагын бодлогоо 2011 онд боловсруулан батлуулж, компанийн бүх салбар болон охин компаниудад танилцуулан, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлсээр ирлээ.

Уг бодлогод “Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулахдаа компанийн нийгмийн хариуцлагын тухай олон улсын стандарт, олон улсын санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны шаардлагууд болон Монгол Улсын холбогдох стандарт, зарчмуудыг хүлээн зөвшөөрч, тэдгээрт нийцүүлсэн үйл ажиллагааг нээлттэй, ил тод явуулж, хүний эрх, хөдөлмөрийн шударга харилцаа, бизнесийн ёс зүйг дээдлэн хэрэгжүүлнэ” хэмээн заасан.

■ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, нүүрсний салбарт улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж үздэг.

Иймд тус компани нь дотоодын болон олон улсын хэмжээнд мөрдөгддөг, сайн засаглалын шаардлагуудыг биелүүлэн ажилладаг төдийгүй нээлттэй, ил тод, хариуцлагатай байдал, шийдвэр гаргалтын энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэхүйц байдлаар дотоод дүрэм, журмуудынхаа хэрэгжилтийг ханган ажилладаг.

Монгол Улсын хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөхийн зэрэгцээ Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг дагаж биелүүлдэг.

Компанийн ёсзүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилгал хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсдад удирдамж, зааварчилгаа болдог. Энэхүү ёсзүйн кодын хүрээнд ажиллагсад болон бусад оролцогч талууд бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтлан ажиллаж бүхий л төрлийн зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх улмаар таслан зогсоохыг эрмэлздэг.

Түүнчлэн оролцогч сонирхогч талуудынхаа итгэлийг хүлээх үүднээс нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэн ажиллаж, уг зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа орон нутгийн иргэд, олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тогтмол тайлагнасаар ирсэн. Компани 2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлсэн үеэс Олборлох Үйлдвэрлэл Ил Тод Байдлын Санаачлага (ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

Тус санаачлагын хүрээнд өнгөрөгч онд Энержи Ресурс компаниас Цогтцэций сумын ЗДТГ, ОУИТБС-ын орон нутгийн дэд зөвлөл, орон нутгийн төрийн бус байгууллагуудын төлөөллүүд болон уул уурхайн компаниуд, орон нутгийн иргэдийг хамруулан нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, ОУИТБС-ын тайлан болон байгаль орчин, орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр хийж буй ажлаа танилцуулж, оролцогч талуудын сонирхсон асуултуудад хариулт өглөө.

■ ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Энержи Ресурс компани нь оролцогч болон сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох, мэдээлэл, туршлага солилцох, үйл ажиллагаандаа хөндлөнгийн мониторинг үнэлгээ хийлгэх, үйл ажиллагаагаа тайлагнах зэргээр гадаад дотоодын олон байгууллагатай үр өгөөжтэй хамтран ажилладаг.



Энэ хүрээнд оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Уг менежментийн төлөвлөгөөний дагуу компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээлэл түгээхийн зэрэгцээ иргэдтэй нүүр тулж уулзан тэдний ойлголт, хандлага, орон нутгийн зүгээс үүсэх нөхцөл байдлыг тодорхойлох, санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилго бүхий компанийн нээлттэй өдөрлөг, олон нийтийн хэлэлцүүлгийг жил бүр зохион байгуулдаг. Мөн орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл байгуулан тууштай хамтран ажиллаж байна. Орон нутгийн зөвлөл нь нутгийн иргэдийн дуу хоолой болж, тэдний санал зөвлөмжийг компанид уламжлах замаар компани болон иргэдийн хооронд нээлттэй, эрх тэгш оролцоог хангах, хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлэн ажилладаг. Түүнчлэн малчид, иргэдийн зүгээс компанийн бүтээн байгуулалтын ажлууд, байгаль орчны мониторинг, нөхөн сэргээлтийн ажилд хяналт тавих байдлаар оролцдог нь компани болон иргэдийн хооронд нээлттэй хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна.

Оролцогч, сонирхогч талуудын оролцоог хангах, үйл ажиллагаагаа ил тод байлгах үүднээс мэдээллийн төв ажиллуулж, сар тутмын “Ухаа Худаг” мэдээллийн хуудсаар дамжуулан орон нутгийн иргэдэд сүүлийн үеийн мэдээ, мэдээллийг хүргэж, үйл ажиллагааны болон тогтвортой хөгжлийн тайланг хагас жил тутамд олон нийтэд нээлттэй тайлагнаж ирсэн. Түүнчлэн үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш бид Ухаа Худаг уурхайтай танилцах аяллыг төр засгийн болон төрийн бус байгууллагууд, сэтгүүлчид, орон нутгийн иргэд, уурхайтай танилцах хүсэлтэй хэн бүхэнд нээлттэй зохион байгуулж ирсэн нь олон нийтийн итгэлийг хүлээх, тэдний санал хүсэлтийг үйл ажиллагаандаа

тусган эргэх холбоотой ажиллахад ихээхэн түлхэц болдог. Тус компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд орон нутгийн удирдлага болон иргэдтэй сайн хөршийн харилцааг хөгжүүлэхэд анхаарч, бүс нутгийн уулзалт, зөвлөгөөнд идэвхи санаачлагатай оролцож, компанийн хэрэгжүүлж буй орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдээр дамжуулан олон нийт, ард иргэдтэй ойр дотно ярилцаж, зөвлөлдөхийг эрхэмлэн ажилласаар ирсэн.

■ ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ

Компанийн үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал мөн байгаль орчинд үүсч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлж цаг тухайд нь арга хэмжээ авч байх зорилгоор орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж, 30 хоногийн дотор эргэн мэдээлэх журмыг хэрэгжүүлэн ажилладаг.

Компанийн хэмжээнд 2014 онд нийт 2 гомдол, 22 хүсэлт хүлээн авснаас нэг гомдол нь нүүрс тээврийн зам дээр мал дайруулсантай холбоотой байсан бол, нөгөө нь тус компаниас хэрэгжүүлж буй Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй байгаа тухай нөлөөллийн бүсийн малчнаас ирүүлсэн гомдол байв. Нүүрс тээвэрлэлтийн зам дээр мал дайруулсан хэргийг Өмнөговь аймгийн Цагдаагийн газарт уламжилж цаашид ийм төрлийн гомдлыг цагдаагийн байгууллага хүлээн авдаг болохыг мэдэгдсэн. Харин хөнгөлөлттэй зээлд хамрагдаж чадахгүй байгаа тухай гомдол гаргагч нь өөр банкинд бизнесийн давхар зээлтэй учраас төслийг хэрэгжүүлэгч орон нутгийн банкнаас тавьж буй шаардлагыг хангахгүй байгаа аж. Иймд уг зээлээ хаасны дараа уг хөтөлбөрийн хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломжтой болох талаар эргэн хариу мэдэгдсэн.

Тайлант хугацаанд хүлээн авсан нийт 22 хүсэлтийн 50% нь компаниас санхүүгийн болон эд материалын туслалцаа хүссэн 9.1% нь Ухаа Худаг уурхай болон Галерей кемпийн үйл ажиллагаатай танилцах, 9.1% нь бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх, хамтран ажиллах тухай хүсэлт, харин үлдсэн нь уурхайд дадлага хийх, Наймдайн хөндийн гүн өрмийн худгийг ашиглах, инженерийн багаас мэргэжлийн дэмжлэг туслалцаа авах тухай байв.



АЖЛЫН БАЙР, ХӨДӨЛМӨРИЙН ХАРИЛЦАА

■ ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

Ажиллагсад нь компанийн амжилтын гол хүчин зүйл учраас чадварлаг боловсон хүчин бий болгох, тэднийг тогтвор суурьшилтай ажиллуулах, сурган хөгжүүлэх нь манай компанийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. Энэ утгаараа компанийн зүгээс ажлын байрны эрүүл, аюулгүй орчинг бүрдүүлж, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шилжин суурьших нөхцлийг бүрдүүлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллаж байна. Тус компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгч болохын хувьд ажиллагсдын эрхийг дээдэлж, тэднийг ижил тэгш боломжоор хангадаг. Ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа ажил горилогсдын мэргэжил, ур чадварын түвшинг эн тэргүүнд харгалзан үзэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд онцгой анхаарал хандуулдаг.

Өмнөговь аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Монгол Улсын Хөдөлмөрийн хуулиуд, тэдгээрийн холбогдох норм, дүрэм, стандартын хэрэгжилтэнд хийх хяналт, шалгалтыг тус компанид жил тутам хийдэг бөгөөд тус газрын гаргасан дүгнэлтээр Энержи Ресурс компанийн хүний нөөцийн алба нь сүүлийн гурван жил дараалан уг шалгалтанд 90-ээс дээш хувийн үнэлгээ авсан тул 2015–2017 он хүртэл гурван жилийн хугацаанд дээрхи төрлийн хяналт шалгалтыг оруулах шаардлагагүйгээр шийдвэрлэжээ.

■ АЖЛЫН БАЙР, ТЭГШ БОЛОМЖ

2014 онд Энержи Ресурс ХХК нь ажиллагсдынхаа ажлын байрыг хадгалах, тэр дундаа орон нутгийн иргэдийг ажил, орлоготой нь хэвээр байлгах чиглэлд нэн тэргүүний ач холбогдол өгч, бүхий л бололцоогоо дайчилсны хүчинд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй бусад уул уурхайн компаниудтай харьцуулан үзвэл ажиллагсдынхаа ажлын байрыг харьцангуй тогтвортой хадгалсан байна.

2014 оны 12-р сарын байдлаар нийт 1,950 ажиллагсдын 41 хувийг орон нутгийн иргэд тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна.


Уул уурхайн салбарт эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь харьцангуй бага хувьтай байдаг бол Энержи Ресурс компани хүний нөөцийн бодлогынхоо хүрээнд шинэ ажилтан сонгон шалгаруулахдаа хүйсийн тэгш байдлыг хангахыг зорьж, тэдний ажлын туршлага, ур чадварыг ижил хэмжээнд авч үзэж, цалин урамшуулал олгох, хөгжиж дэвших ижил тэгш боломжийг олгодог. Энэ бодлогын хүрээнд компанийн нийт ажиллагсдын 15 хувийг эмэгтэй ажиллагсад эзэлдэг бөгөөд эдгээрийн 34 хувь нь удирдах албан тушаал эрхэлж байна.

Бид ажилтны нас, хүйс, орон нутгийн иргэн байх эсэхээс хамаарсан цалин хөлсний ялгавартай байдлыг хүлээн зөвшөөрдөггүй ба цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсролын түвшин, мэдлэг, туршлага болон зэрэг дэв зэргээс шалтгаалдаг.


Компанийн ажиллагсдын мэдээлэл

	2012/12/31	2013/12/31	2014/12/31
1. Нийт ажиллагсдын тоо	2568	2272	1950
2. Нийт эмэгтэй ажиллагсдын тоо	449	324	296
3. Орон нутгийн ажиллагсдын хувь	35.6%	43.3%	40,6%


Ажиллагсдын насны ангилал (2014)




Эмэгтэй удирдах албан тушаалтны эзлэх хувь (2014)



Эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь (2014)



Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь (2014)



■ АЖИЛЛАГСДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2014 онд ажиллагсдын шилжилт хөдөлгөөн 18.0%-д хүрч өнгөрөгч оныхоос 9.9%-иар буурсан байна. Тайлант онд тус компани нь зах зээлийн хүнд нөхцөлд ажиллагсдынхаа ажлын байрыг хадгалж авч үлдсэн, мөн тэдний нийгмийн асуудалд анхаарч хөнгөлөлт, хангамжийн бодлого хэрэгжүүлж, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн зэрэг шалтгаанууд шилжилт хөдөлгөөн багасахад нөлөөлсөн.

■ СУРГАЛТ, ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн.

2014 онд давхардсан тоогоор нийт 634 ажилтныг 27 төрлийн сургалтанд хамруулсан бөгөөд үүнээс 153 хүнийг ерөнхий ур чадварын 19 төрлийн сургалтанд, 481 хүнийг 8 төрлийн мэргэжлийн сургалтанд тус тус хамруулжээ.

■ АЖИЛЛАГСДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Тус компанийн санхүүгийн нөхцөл байдал болон хувь хүний ажлын гүйцэтгэл, багийн гүйцэтгэлээс хамааран ажиллагсдад гүйцэтгэлийн урамшууллыг тооцон олгодог бөгөөд орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл олгох, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийн гишүүдийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, мөн хүүхдүүдийнхээ сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллагсдынхаа нийгмийн асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн.

Тухайлбал 2014 онд нийт 1525 ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулхад компанийн зүгээс 310.9 сая төгрөгийг үзлэг оношилгооны зардалд зарцуулсан байна. Мөн ажиллагсдыг суурьшуулах бодлогын хүрээнд Цогтцэций суманд барьж байгуулсан орон сууцны “Цэций” хороололд одоогийн байдлаар 400 орчим ажиллагсад гэр бүлийнхээ хамтаар тохь тухтай амьдарч байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

■ ТАТВАР ТӨЛӨЛТ

Энержи Ресурс ХХК нь үйл ажиллагаа эхлүүлсэн жил буюу 2009 онд 22 тэрбум, 2010 онд 84 тэрбум, 2011 онд 170 тэрбум, 2012 онд 209, 2013 онд 123 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлсэн. 2014 онд дан ганц нүүрсний салбар гэлтгүй уул уурхайн салбарын хувьд амаргүй, хүндхэн жил байсан боловч компанийн зүгээс бүтээмжээ нэмэгдүүлэх, зардлаа бууруулах, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтад шилжих зэргээр дотоод нөөц бололцоогоо дайчлан ажилласны үр дүнд өмнөө тавьсан зорилго, зорилтуудаа бүрэн гүйцэд биелүүлсэн төдийгүй 74 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

■ ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Орон нутаг төдийгүй улс орны хэмжээнд хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш Ухаа Худагт өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогц утгаар бүрдүүлж байна.

2014 онд нийт 4.1 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц болон орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд болон томоохон бүтээн байгуулалтанд зарцуулсан байна. Түүнчлэн уурхайн дэд бүтцийг орон нутгийн дэд бүтцийн хөгжилтэй уялдуулах бодлогын хүрээнд төвийн эрчим хүчний системээс алслагдсан Цогтцэций сумыг тог цахилгаан, ундны цэвэршүүлсэн усаар хангадаг.

Компани өөрийн үйл ажиллагааны хүрээнд дотоодын нийт 2100 гаруй аж ахуйн нэгжтэй бэлтгэн нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч хэлбэрээр хамтран ажиллаж ирсэн байна. Зөвхөн 2014 оны байдлаар дотоодын 440 орчим аж ахуйн нэгжээс нийт 443 тэрбум төгрөгийн хэрэгцээт бараа, үйлчилгээг худалдан авчээ. Бид бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчим баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтрахыг нэн тэргүүнд эрхэмлэдэг. Өнгөрөгч онд Өмнөговь аймгийн хэмжээнд бараа

материал, тээврийн үйлчилгээ, барилгын материал, ажил үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл зэрэг нийт 1.1 тэрбум төгрөгийн худалдан авалт хийсэн байна.

Говь нутгийн малчдад уул уурхайгаас үүсэх сөрөг нөлөөлөл зам тээвэр, тоосжилт гээд багагүй бэрхшээл тулгарч байдагт анхаарч тус компаниас малчин өрхүүдэд өвөл, хаврыг өнтэй давахад нь дэмжлэг болгон өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг жил бүр уламжлал болгон хэрэгжүүлж ирлээ.

Мөн Даланзадгадын дулааны цахилгаан станц болон Цогцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор зэрэг сумдад жил тутам 45,000 орчим тонн эрчим хүчний нүүрс үнэ төлбөргүй нийлүүлж ирсэн.

Тайлант онд Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор сумдын түүхт 90 жилийн ойн баярууд тохиосонтой холбогдуулан ойн нэгдсэн арга хэмжээ, баяр наадамд зориулан компанийн зүгээс дээрх сумдад тус бүр 20 сая төгрөгийн хандив өргөлөө.

Нийгэм, орон нутагт оруулсан хөрөнгө оруулалтын нэгтгэл (2014)

Хөрөнгө оруулалтын чиглэл	Төгрөг
1. Орон нутгийн дэд бүтцийн хөгжил	2,104,426,810
2. Төсөл хөтөлбөрүүд	889,304,517
3. Хандив, тусламж	37,500,000
4. Орон нутгийн худалдан авалт	1,114,040,474
НИЙТ	4,145,271,801

Бид орон нутгийн дэд бүтэц, боловсролын хүртээмж, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, мэдлэг чадварыг сайжруулахад анхаарал тавин ажиллахаас гадна малчдын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх боломжийг бий болгож, чадавхижуулах чиглэлээр бие даасан төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн ажилладаг.

■ ОРОН НУТГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Компани нь нийгмийн нөлөөллийн үнэлгээ, хүн ам, эрүүл мэнд, хүний эрх, соёлын өв зэрэг нийгмийн олон чиглэлийн суурь судалгаа болон иргэдийн нээлттэй хэлэлцүүлгийн санал санаачлагыг үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийт болон засаг захиргааны байгууллагуудын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлсээр ирлээ. Тайлант хугацаанд компанийн зүгээс олон нийт, орон нутгийн иргэдэд зориулан дараах төсөл, хөтөлбөр, санаачлагуудыг хэрэгжүүлэн ажиллав.

“Мөрөөдөл” сургуулийн амжилт ахиж байна

Өмнөговь аймгийн Цогтцэций суманд олон улсын жишигт нийцсэн боловсролын орчин үеийн томоохон цогцолбор болох “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэг, дотуур байрны барилга байгууламжийг аймгийн ЗДТГ болон Энержи Ресурс компанийн 35/65 хувийн хамтарсан хөрөнгө оруулалтаар барьж байгуулж, ашиглалтанд оруулсан билээ.



Уг цогцолборын барилгыг боловсролын байгууламжийн стандарт шаардлагад нийцүүлж, анги танхим, спорт заал, урлагийн заал, номын сан зэргийг орчин үеийн техник хэрэгслээр иж бүрэн тохижуулж, сурагчдын сурч, боловсрох ая тухтай орчныг цогцоор нь бүрдүүлсэн. Энержи Ресурс компанийн дэмжлэгтэйгээр сургалтын менежментийн хамгийн орчин үеийн аргачлалыг нэвтрүүлж, англи хэлийг эх хэлний түвшинд эзэмшүүлэх “Dyn Ed” хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажилладаг уг сургууль 2013–2014 оны хичээлийн жилд сургалтын үнэлгээгээ өмнөх оныхоос 4 хувиар ахиулж, 2014 оны “Аймгийн тэргүүний хамт олон”-оор шалгарчээ.

Говь Шанхын уртын дууны албан ёсны эрхийг баталгаажуулав

Өмнийн говийн ард түмний гайхамшигт соёлын өвүүдийн нэг хэдий ч өнөөдөр нутгийн хэдэн өвгөчүүдээс өөр мэдэх хүнгүй шахам болоод байгаа Говь Шанхын уртын гурван дуу болох Хурдан сайхан,



Холч морь, Өндрийн өвс дуунуудыг сэргээн таниулах, нутгийн залуусын дунд түгээн дэлгэрүүлэх үйлсийг компаниас санаачлан 2010 оноос эхлүүлж, жил бүр уртын дууны сургалт болон уралдааныг нутгийн иргэдийн дунд уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн. 2014 онд Цогтцэций сумын түүхт 90 жилийн ойг угтан зохион байгуулсан Говь Шанхын уртын гурван дууны сургалтанд Цогтцэций, Цогт-Овоо, Булган, Даланзадгад, Сэврээ сумдын 8–70 насны нийт 32 хүн хамрагдсан бол тав дахь жилдээ болж буй уртын дууны уралдаанд 26 оролцогч авьяас чадвар, хоолойн цараагаараа өрсөлдлөө. Тоглолтын үеэр Энержи Ресурс компани Монгол Улсын Соёлын өвийн төвтэй хамтран Говь Шанхын гурван дууны өв тээгч ахмадуудад өв тээгчийн батламжийг гардуулж, Цогтцэций сумын засаг захиргаанд Говь Шанхын гурван дууны патентын эрхийг шилжүүлэн өгсөн тэмдэглэлт үйл явдал тохиолоо.

Монгол Ганжуур, Данжуурыг хөрвүүлэх үйлс

Энержи Ресурс нь компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд биет болон биет бус өвийг хамгаалах, хадгалах хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэн ажилладаг. Энэ ажлын хүрээнд Цогт Цагийн Хүрдэн соёлын төвийн хүсэлтийг хүлээн авч, 2013 оноос эхлэн Монгол Ганжуур, Данжуур их хөлгөн судрыг кирилл бичигт хөрвүүлэн бүтээж, олон нийтийн хүртээл болгох, өв соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулан, ном судар бүтээх ариун үйлсэд хамтран ажиллаж



байна. Одоогийн байдлаар Цогт Цагийн Хүрдэн соёлын төвийнхөн их хөлгөн судрын хөрвүүлгийн эхний 90 ботийг орчуулан хэвлүүлсэн байна. Уламжлалт өв соёлыг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, орчин цагийн монгол хэлний үгийн санг баяжуулах, үндэсний бахархлыг бий болгох гээд өндөр ач холбогдолтой энэхүү буянт үйлсийг компанийн зүгээс талархан дэмжиж, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлсээр байна.

“Цогтцэцийн жонон” морин хуурын хамтлаг төрлөө

Дундговь аймгийн харьяат, морин хуурч, МУСТА Ё.Нэргүй Цэций жононгийн аялгууг найруулж, Төв халхын жонон нэртэй бүтээл бий болгосон. Энержи Ресурс компаниас энэхүү бүтээлийг түгээн дэлгэрүүлэх үүднээс түүнтэй хамтран аймаг, сумын мэргэжлийн хуурчдад зориулсан сургалт явуулж эхэлсэн. Ингэснээр Төв халхын жонон аялгууг бүрэн эхээр нь заалгасан мэргэжлийн хуурчид орон нутгийн хүүхдүүдэд зааж, дэлгэрүүлэн улмаар 15 хүүхдийг сонгон шалгаруулснаар “Цогтцэцийн жонон” нэртэй морин хуурын хамтлаг 2014 онд байгуулагдаж, анхны тайлан тоглолтоо амжилттай зохион байгууллаа.

Тайлан тоглолтын үеэр компанийн зүгээс хамтлагийг улсын бүртгэлд бүртгүүлсэн гэрчилгээг гардуулж, мэргэжлийн морин хуур, их хуур хөгжмийн зэмсэг, тоглолтын иж бүрэн хувцас хэрэгсэл зэрэг нийт 12.5 сая төгрөгийн эд хэрэгслийг хамтлагийн хэрэгцээнд зориулан сумын Соёлын төвд хүлээлгэн өглөө.



Сумын музейд уул уурхайн танхим нээгдлээ

Цогтцэций сумын 90 жилийн ойг угтан Орон нутгийн музейд эрдэс баялгийн өлгий нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниудын түүхэн замнал, үйл ажиллагааг харуулсан үзэсгэлэнгийн танхим нээгдлээ.

Орон нутгийн музейн тусгай танхимд Энержи Ресурс компанийн түүхэн замнал, үйлдвэрлэл, дэд бүтцийн бүтээн байгуулалтуудыг харуулсан үзмэр, мэдээллүүд байрлуулж, тохижууллаа. Сумын музейн сан хөмрегийг баяжуулах, үзмэрийг шинэчлэх, мэдээллийн санг бүрдүүлэхэд Цогтцэций суманд үйл ажиллагаагаа явуулдаг уул уурхайн компаниуд ийнхүү хувь нэмрээ орууллаа.



Сум дундын шинэ эмнэлэгт хөрөнгө оруулалт хийнэ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 90 жилийн ойг тохиолдуулан орон нутгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, жишиг болгон хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулах зорилгоор Цогтцэций суманд 2014–2015 онд ашиглалтанд орох 50 ор бүхий сум дундын эмнэлэгт шаардлагатай орчин үеийн тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл, тоноглолоор хангах үүргийг Энержи Ресурс компани хүлээн ажиллаж байна.

Энэ дагуу Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газар, Цогтцэций сумын ЗДТГ, сум дундын эмнэлэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж, эмнэлгийн мэс засал, үйл онош, яаралтай тусламжийн чиглэлийн үйл ажиллагаанд нэн шаардлагатай тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангах үүргийг хүлээн нийт 500 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, хоёр тал гарын үсэг зурлаа. Уг эмнэлэг нь 2015 онд ашиглалтанд орж, бүрэн хүчин чадлаар ажиллах бөгөөд Цогтцэций сум төдийгүй говийн бүсийн эрүүл мэндийн чанарыг дээшлүүлэхэд томоохон алхам болох юм.



Малчдын тогтвортой амьжиргааг дэмжиж байна

Уул уурхайн хөгжилтэй зэрэгцэн уламжлалт мал аж ахуй эрхлэгч малчин өрхийн амьжиргааг дэмжих, тэдний мал аж ахуй, фермерийн аж ахуй, газар тариалан болон бусад бизнес эрхлэлтийг дэмжих чиглэлээр “Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих” хөтөлбөрийг 2012 оноос боловсруулан хэрэгжүүлж байна.



Нэн тэргүүнд хөтөлбөрт хамрагдах Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдын 63 малчин өрхийн дунд нийгэм, эдийн засгийн байдлын мониторинг судалгаа мөн тэдний амьжиргааг өнөөгийн нөхцөл байдал, аж ахуй эрхлэх сонирхол, чадавхи, эрэлт хэрэгцээг тодорхойлсон. Улмаар 49 малчин өрх цаашид эрхлэх бизнесийн чиглэлээ тодорхойлж, бичил төсөл боловсруулж, хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд бизнесийн төрөл бүрийн чадавхижуулах сургалтанд хамрагдсан.

2014 онд Хас банктай хамтран дээрх малчин өрхүүдэд бичил зээл олгох 3 жилийн хөтөлбөрийг эхлүүлж, одоогийн байдлаар нөлөөллийн бүсийн гурван сумын нийт 15 малчин өрхөд хөнгөлөлттэй зээл олгожээ. Малчдыг өрхийн бизнесээ өдөр тутам хөтлөн явуулах, өрхийн орлогоо сайжруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор орон нутгийн “Амжилтын томьёо”, “Говийн хөгжлийн зуун” ТББ-ууд бизнесийн зөвлөх үйлчилгээ, сургалт явуулж, уг төслийн түншээр хамтран ажиллаж байна.



Говьд газар тариалан хөгжүүлэх төсөл

Цогтцэций сумын нутаг нь хуурай газрын эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын эрс өөрчлөлттэй, хүчтэй салхилж шороон шуурга болох нь олонтаа тул Энержи Ресурс компанийн байгаль орчны менежмент, орон нутгийг дэмжих ажлын хүрээнд 15 га хамгаалалтын ойн зурвасыг 2011 онд байгуулсан.

Уг зурвасыг байгуулснаар цөлжилтөөс хамгаалах, салхины хүчийг бууруулах, хөрсний усны тэнцвэрт байдлыг хангах зэрэг олон талын ач холбогдолтойгоос гадна уг талбайд орон нутгийн иргэд хүнсний ногоо тариалах, ашиг орлогоо нэмэгдүүлэх боломж бүрдсэн. Компанийн зүгээс ногоо тарьж байгаа иргэдэд сургалт, арга зүйн зөвлөгөө өгч нэгдсэн усалгаагаар ханган ажиллаж байна.

2014 онд сумын ЗДТГ-тай хамтран 100 орчим өрхөд нэмэлтээр талбай хуваарилсан бөгөөд эдгээр өрхүүдэд мэргэжил, аргазүйн сургалтуудыг зохион байгууллаа. Уг сургалтанд нийт 60 гаруй иргэн хамрагдан хөрс бэлтгэх, боловсруулах, эвдэрсэн хөрсний нөхөн сэргээлт, хүнсний ногооны ашиг тус болоод тариалах арга технологи, хүлэмжийн аж ахуй буюу хамгаалагдсан хөрсний аж ахуй, жимс жимсгэний мод тариалах, хайлаас, сухай, шар хуайс зэрэг говийн нөхцөлд тохиромжтой мод суулгац тарих, арчлах, ногоо даршлах зэрэг сэдвүүдээр мэдээлэл авлаа. Тайлант онд нийт 80 өрх 20 гаруй нэр төрлийн төмс, хүнсний ногоо тарьж ургуулж, ургацын баяраа өргөн дэлгэр тэмдэглэсэн.



Мод тарих үндэсний өдөрт нэгдэв

2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар Мод тарих үндэсний өдрийг зарлан тэмдэглэх болсноос хойш Энержи Ресурс компанийн хамт олон энэхүү санаачилгыг дэмжин жил бүр мод, суулгац тарьсаар ирсэн.

Мод тарих үндэсний өдрөөр буюу 2014 оны 5-р сарын 10,11-ний өдрүүдэд компанийн ажиллагсад Ухаа Худаг уурхай болон Цогтцэций суманд мод тарих аян өрнүүлж, Тавантолгой нисэх онгоцны буудал орчимд 210 мод, “Цэций” хороолол орчимд 70 мод,

Галерей кемпийн тохижилтонд 46 мод, уурхайн засварын газар 250 мод нийтдээ 576 мод тарилаа. Түүнчлэн Цогтцэций сумын айлуудын мод тарих, ногоон байгууламж байгуулах үйлст дэмжлэг үзүүлж, 100 ширхэг суулгацыг Цогтцэций сумын ЗДТГ-т хүлээлгэн өгчээ.

Энержи Ресурс компанийн байгаль орчны багийн зүгээс бүх нийтээр мод тарих ажилд идэвхи санаачлагатай оролцсон Тавантолгой нисэх онгоцны буудлын хамт олон, Ус хангамжийн сангийн баг, “Мөрөөдөл” сургууль, Паблик сервис ХХК, “Цэций” хорооллын оршин суугчид, Ухаа Худаг салбарын авто баг болон уурхайн засварын газрын хамт олонд талархал илэрхийллээ.

Нутгийн ахмадуудад хүндэтгэл үзүүллээ



Энержи Ресурс компаниас сар шинийн баярыг угтан орон нутгийн өндөр настан, азай буурлууддаа хүндэтгэл үзүүлдэг сайхан уламжлалыг тав дахь жилдээ хэрэгжүүлж байна. Өнгөрсөн онд сар шинийг угтан Өмнөговь аймгийн Баян-Овоо, Ханбогд, Цогтцэций, Ханхонгор сумдын 70-аас дээш насны нийт 370 ахмад буурлыг уламжлал ёсоор хүлээн авч, гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүллээ. Компанийн зүгээс орон нутгийн жижиг, дунд бизнесийг дэмжих зорилгын хүрээнд дээрх арга хэмжээнд шаардагдсан 13 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг зөвхөн орон нутгаас худалдан авсан байна.

Булаг шанд, уст цэгүүдийн орчны хог хаягдлыг цэвэрлэв

Жил бүр төслийн үйл ажиллагаа явагддаг газар нутагт байрлах уст цэгүүдийн хатуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг уламжлал болгон зохион байгуулсаар ирсэн.

2014 онд Цогтцэций сумын нутаг дэвсгэрт байрлах Мухар гашууны булаг, Жирэм булаг, Хөөвөрийн задгай, Дугантын задгай, Шинэ ус, Маахууз, Хулсан ус, Гучин ус, Хоолойн гуч, Бунхант зэрэг 10 орчим уст цэг, худгийн хатуу хог хаягдлыг цэвэрлэж, нийт 3 куб метр орчим ахуйн хог хаягдлыг Цогтцэций сумын хатуу хог хаягдлын цэгт хүргүүллээ.

Мал усалгааны худгуудыг хүлээлгэн өглөө



Компанийн зүгээс Цогтцэций сумын Цагаан-Овоо багийн нутаг Наймантын хөндийн гүний 6 ба 10 дугаар худгуудын дэргэд малчдын ахуйн болон мал усалгааны хэрэгцээнд зориулсан хоёр худгийг шинээр гарган, тоноглож өгсөн. Эдгээр худгууд нь мотор ажиллуулах, ховоо татах зэрэг биеийн хүчний ажиллагаа шаардахгүй, зөвхөн цоргоор малаа услах боломж бүхий хялбар шийдэлтэй тул малчдын мал усалгааны өдөр тутмын ажлыг ихээхэн хөнгөвчлөх давуу талтай. Тайлант онд орон нутгийн удирдлагууд болон малчдын хүсэлтээр эдгээр худгуудыг нээж, ойролцоо нутагладаг малчдад хүлээлгэн өглөө.

Өвс тэжээлийн тусламж

Компанийн нийгмийн хариуцлагын хүрээнд нутгийн малчдад өвөл, хаврыг өнтэй даван туулахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүр нөлөөллийн бүсийн малчин өрхүүдэд өвс тэжээлийн тусламж үзүүлсээр ирсэн.

2014 оны хувьд өвс тэжээлийн хандив тусламжинд зориулан нийт 6100 боодол өвс худалдан авсан бөгөөд Ханбогд сумын малчин өрхүүдэд 800 боодол, Баян-Овоо суманд 700 боодол, Ханхонгор суманд 1600 боодол, Цогтцэций суманд 3000 боодол өвс тараах ажлыг сумдын удирдлагууд, багийн засаг дарга нар, орон нутгийн сайн дурын зөвлөлийн гишүүдтэй хамтран амжилттай зохион байгууллаа.



БАЙГАЛЬ ОРЧИН, ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА ЭРҮҮЛ АХУЙ (БОХАБЭА)

Энержи Ресурс компани нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд ажиллагсдынхаа аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжууд болон олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартуудыг мөрдлөг болгон ажилладаг. 2014 онд зах зээлийн хямралтай нөхцөл, эдийн засгийн хүндрэлтэй байдлаас шалтгаалан уурхайн үйл ажиллагаа зогсонги байдалтай байсан ч компанийн зүгээс байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг аль болох өндөр гүйцэтгэлтэй хэрэгжүүлэх зарчмыг баримтлан ажиллалаа.

■ БОХАБЭА -ЫН УДИРДЛАГА

Энержи Ресурс компани нь БОХАБЭА удирдлагын тогтолцоогоо сайжруулах үүднээс олон улсын ISO 14001:2004 (Байгаль орчны удирдлагын тогтолцоо), OHSAS 18001:2007 (Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо) стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь Энержи Ресурс компанийн бүх үйл ажиллагаанд нэвтэрч, компанийн БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем юм. Нэгдсэн удирдлагын тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлснээр аливаа эрсдлийг цогцоор илрүүлж, үнэлж, хянах боломж бүрдэхээс гадна нөөцийг үрдүнтэй ашиглаж, зардал буурах ач холбогдолтой. Удирдлагын тогтолцоо нь компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөх юм.

■ БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГО, ЧИГ БАРИМЖАА

Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын банк санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцүүлсэн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Ухаа Худаг

төсөл эхлэхээс өмнө хийж гүйцэтгэн, төслөөс үүдэлтэй байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилладаг.

Ухаа Худаг уурхайн хүрээнд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн бие даасан менежмент төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлж байна. Мөн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг хянах зорилгоор орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулж, гадаад дотоодын мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг.

Оролцогч талуудын гол төлөөлөл болох орон нутгийн иргэдийн байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургуулийн сурагчид болон нутгийн малчид, иргэдэд ойжуулалт, зүлэгжүүлэлт, хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаар сургалт явуулдаг. Түүнчлэн орчны хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулж, хөндлөнгийн хяналт хийлгэдэг.

■ БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Энержи Ресурс компани нь байгаль орчны нарийвчилсан үнэлгээнээс гадна жил бүр төслийн үйл ажиллагаа явагдаж буй Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханхонгор, Ханбогд, Баян-Овоо сумдын нутагт хөрс, ургамал ба амьтны аймгийн судалгааг байгаль орчны мэргэжлийн байгууллага болон эрдэмтэн судлаачидтай хамтран хийж гүйцэтгэдэг. Өнгөрөгч онд доорх судалгаануудыг хийж гүйцэтгэсэн.

Хөрсний бохирдлын судалгаа

Орчны хяналт шинжилгээний ажлын хүрээнд хөрсний бохирдлын мониторингийн 10 цэгээс дээж авч ALS MINERALS итгэмжлэгдсэн лабораторид хүнд металын шинжилгээ хийлгэсэн. Судалгаа хийгдсэн газар нутгуудад цөлөрхөг хээрийн мараалаг, цөлөрхөг

хээрийн хужирлаг бор, цөлөрхөг хээрийн нугархаг бор, цайвар бор зэрэг хэв шинжийн хөрс тэмдэглэгдсэн бөгөөд судалгааны үр дүнд үндэслэн хөрсний хэв шинжийн болон элэгдэл эвдрэлийг тодорхойлсон.

Шинжилгээний дүнгээс харахад хүнцлээс бусад элементийн агууламж MNS5850:2008 Хөрс бохирдуулагч бодис элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ стандартад заагдсан хэмжээнд байсан байна. Харин хүнцлийн (As) агууламж бүх цэгүүд дээр стандартад заагдсан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хоёр дахин өндөр агууламжтай гарсан. Энэ нь тухайн бүс нутгийн газрын гадаргын эрдэс чулуулгийн бүтэц найрлагын онцлогтой холбогдон тайлбарлагдах бөгөөд энэ талаар хийсэн эрдэмтдийн судалгаа шинжилгээний бүтээл цөөнгүй байдаг. Хүнцлийн агууламж бүс нутгийн хөрсний найрлаганд өндөр үзүүлэлттэй болохыг бид төслийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн үеэс эхлэн жил бүрийн судалгаагаар давхар тодорхойлж байгаа болно.

Ургамлын аймгийн судалгаа

Ухаа Худаг уурхай орчим, Наймантын хөндий, Нисэх буудал, Цагаан хад, Ухаа Худгаас Гашуун сухайт хүртэл зам дагуу, Баруун наран уурхай, Баруун наран уурхайгаас Ухаа Худаг уурхай хүртэл зам дагуу байрлах мониторингийн цэгүүд дээр ургамлын бичиглэл үйлдэн ашиглалтын талбай, ойжуулах, нөхөн сэргээх газрын ургамал, төрх байдлыг судалсан. Нийтдээ 13 овгийн 51 төрлийн 75 зүйлийн бүрдэлтэй байна. Үүнээс уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй нэрвэгдэж устгах аюулд хүрсэн ургамал байхгүй байна.

Амьтны аймгийн судалгаа

2014 онд Ухаа Худаг уурхай, Наймант болон Наймдайн хөндий, Цэций хайрхан уул, нүүрс тээврийн зам дагуу газар нутгуудад зэрлэг амьтны ажиглалт судалгааг 1, 5, 7, 9-р саруудад хийж гүйцэтгэсэн. Ажиглалт судалгааны үр дүнд тулгуурлан амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Төслийн талбай нь хулан, хар сүүлт зээр, цагаан зээр, аргаль зэрэг нүүдлийн тууртан амьтдын шилжилт, хөдөлгөөний гол бүс нутгийг дайран гардаг тул амьтны аймгийн мониторинг судалгаа хийх нь ихээхэн ач холбогдолтой.

Амьтны аймгийн мониторинг судалгааг хийх нь эдгээр нүүдлийн амьтдын шилжилт хөдөлгөөний гол замналуудыг тодруулах, тэдгээрийг хамгаалах, болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх менежментийг боловсруулах зэрэгт өндөр холбогдолтой. Говь цөлийн бүсийн тураг (том биетэй) хөхтөн амьтдын амьдралын хэв маяг нь нүүдлийн шинж чанартай байгаль цаг уурын нөхцлөөс хараат байдаг тул нэг газар нутагтаа байнга буюу тогтмол байршдаггүй онцлогтой.

Шувуудын судалгаа

Өнгөрөгч онд төслийн талбайн орчим үзэгддэг суурин болон нүүдлийн шувуудын ажиглалт судалгааг явуулж мэдээллийн сан үүсгэсэн. 2013 онд хийгдсэн Зэрлэг

амьтдын судалгаагаар 7 багийн 51 зүйлийн шувууд тэмдэглэгдсэн байдаг ба төслийн талбай орчимд буюу нүүрс тээврийн хатуу хучилттай зам дагуу тэмдэглэгдсэн махчин шувуудын ихэнх нь голчлон жижиг шувуудаар хооллодог бөгөөд цөөн хэдэн зүйлийн шувуу сэг, зэм болон жижиг хөхтөн амьтдаар хооллодог. Мэдээллийн санг үүсгэхдээ 2014 оноос эхлэн үзэгдсэн шувуудыг бүртгэж эхэлсэн бөгөөд мэдээллийн сан нь цаашид жил ирэх тусам баяжигдсаар байх юм.

■ ГАЗАР АШИГЛАЛТ БА НӨХӨН СЭРГЭЭЛТ

Газрыг зөв зохистой ашиглан, нөхөн сэргээж улмаар ирээдүйд бэлчээр болон бусад байдлаар ашиглах боломжтой болгож үлдээх нь хариуцлагатай уул уурхайн нэн чухал хэсэг юм. Ухаа Худаг төслийн хүрээнд бид нийт 22,710 га газрыг ашиглах эрхтэй бөгөөд үүнээс 49.9% нь уул уурхайн зориулалтаар, 41.4% уул уурхайн дэд бүтцийн зориулалтаар, 3% нь үйлдвэрийн барилга байгууламж, 6.5% ажиллагсдын орон сууцны зориулалтаар тус тус ашиглаж байна.

Энержи Ресурс компани нь хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага түвшинд барих зорилго тавин ажилладаг бөгөөд жил бүр нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулан ажилладаг. 2014 онд бид байгаль орчны нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж хэрэгжүүллээ

Туршилтын талбай

Биологийн нөхөн сэргээлтэнд зориулсан мод, бут, сөөг, нутгийн ургамал болон олон наст ургамлыг туршилтын журмаар ургуулан тухайн бүс нутагт зохицсон ургамлыг сонгон шалгаруулж улмаар үржүүлэн нөхөн сэргээлт болон орчны тохижилт, ойн зурвас байгуулах ажилд ашиглах зорилгоор 2009 онд 2.5 га талбайд байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайг байгуулсан билээ. Одоогоор тус талбайд 24 төрлийн 60,000 гаруй мод сөөг, бутлаг ургамал ургаж байна.

2014 онд уг туршилтын талбайд сухай 1500 ширхэг, жигд 500 ширхэг, хайлаас 3000 ширхэг, заг 100



ширхэг, нийт 5100 ширхэг мод сөөгийг үр болон мөчрөөр тарьж ургууллаа. Мөн 20 мянга орчим тарьц суулгацыг бойжуулж үүнээс 8500 орчим тарьц суулгацыг ойн зурвас, төслийн талбайн ногоон байгууламжийн үйл ажиллагаа болон Цогтцэций сумын иргэдэд нийлүүлсэн.

Хаягдал чулуулгын овоолгын нөхөн сэргээлт

Байгаль орчны багаас уурхайн хаягдал чулуулгын овоолго дээр нийт 3 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийжээ. Овоолгын гадаргууг Монгол Улсын холбогдох стандартад нийцүүлэн 18 хэмээс багагүй налуутай болгон техникээр жигдэлж, 30 см орчим зузаантай шимт хөрсөөр хучдаг байна. Энэхүү талбайд саман ерхөг, эмзэг түрүүт өлөнгө, сибирь хялгана зэрэг олон наст ургамлаас гадна шар бударгана, орог тэсэг, хармаг, коржинскийн харгана зэрэг нутгийн ургамлуудыг тарьжээ. Уг талбайн 1 орчим га газарт гурван хэмжээст Жеомат тусгай хучаас дэвсэж, тарилт хийсний үр дүнд хөрсний гулгалт багатай, ургамал ургахад таатай нөхцөл бүрдсэн байна. Мөн борооны ус зайлуулах системийг чулуун далан, шуудуугаар шийдэж өгчээ. Ийнхүү уурхайн хаягдал чулуулгын овоолго дээр ногоон байгууламж үүсгэх нөхөн сэргээлтийн ажлыг амжилттай туршсан нь цаашид уурхайн нөхөн сэргээлтийг цогцоор нь хийж хэрэгжүүлэхэд ихээхэн үр дүнтэй алхам боллоо.

Шороон замын нөхөн сэргээлт

Энержи Ресурс компани нь төслийн хэмжээнд бүтээн байгуулалтын үед ашиглаж байсан түр замуудад техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг жил бүр төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж байгаа ба энэ онд Таван – толгой нисэх буудлын орчим ашиглаж байсан түр зам дээр биологийн нөхөн сэргээлт хийх ажлыг 2500м² талбайд гүйцэтгэсэн.

Биологийн нөхөн сэргээлт хийсэн газар нь нисэх буудлын засмал зам дагуу ашиглаж байсан түр зам юм. Нөхөн сэргээлтийг хийхдээ түр замыг хашиж говь цөлийн унаган ургамал болох хайлаас, сухай, заг зэрэг моддыг тарьж суулгасан. Замын нөхөн сэргээлтийн энэ хэлбэр нь элсний нүүдлийг тогтоох, дуу чимээ багасгах, автомашины утаанаас ялгарч буй нүүрсхүчлийн хийг шингээх, засмал замаас салбарласан олон салаа зам дахин гарахаас сэргийлэх зэрэг өндөр ач холбогдолтой юм.

Ойн зурвас төсөл

Цогтцэций сумын нутаг нь эх газрын хуурай эрс тэс уур амьсгалтай, агаарын температурын зөрүү өндөртэй, жилдээ 120мм-с бага хур тунадас унадаг, салхины дундаж хурд 5м/с байдаг ч зарим үед хүчтэй салхилж 34 м/с хүртлэх хурдтай шороон шуурга болдог тул салхины хамгаалалтын ойн зурвас байгуулах ажлыг компаниас 2011 онд санаачлан эхлүүлсэн. Энэхүү хамгаалалтын ойн зурвас нь дан ганц салхи шуурга, элсний нүүдлээс хамгаалаад зогсохгүй нутгийн иргэдэд хүнсний ногоо тарих боломжийг олгож, иргэдийн амьжиргааг дэмжихэд

багагүй нэмэр болж байна. Хамгаалалтын ойн зурвас нь одоогийн байдлаар 10 га талбайг эзэлж буй бөгөөд цаашид 50 га хүртэл өргөжүүлэхээр төлөвлөж байна. Өнгөрсөн гурван жилийн хугацаанд тарьсан хайлаас, улиас, жигд, сухай, чацаргана зэрэг 5 төрлийн 12 мянган мод сөөгийн амьдралын хувь 90%-ээс дээш үзүүлэлттэй байна. Мод сөөгний усалгаанд сүүлийн үеийн дэвшилтэт технологи болох дуслын усалгааны системийг ашиглаж байгаа. Энэ нь усны зарцуулалт ба ууршилтын алдагдал хамгийн багатай арга юм. Сумын иргэдэд зориулж ойн зурвасын дотор усалгааг бүрэн шийдсэн 5 га ногооны талбай гаргасан ба сум орон нутгийн иргэд жил бүр төмс, манжин, лууван, байцаа, сонгино болон бусад нарийн ногоо тарьж жилд дунджаар 40 гаруй тонн ногоо хураан авч байна. Мөн иргэдийг хураасан ногоогоо борлуулахад нь туслах зорилгоор жил бүр ургацын баяр, үзэсгэлэн худалдааг зохион байгуулдаг.



■ БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ДЭМЖИХ

Шувуудад хиймэл үүр хийж, байрлуулав

Ухаа Худаг уурхай орчмын бүс нутагт амьдарч байгаа өдрийн болон шөнийн идэвхит махчин шувуудын амьдрах орчныг дэмжих зорилгоор шувууны хиймэл үүр хийж суурилуулах ажлыг 2013 оноос эхлэн зохион байгуулсан. Энэ ажлыг үргэлжлүүлэн тайлант оны намар ойн зурвас, Сэвхүүлийн хөндий, Цэций хайрханы өвөр, Хээрийн булаг зэрэг тодорхой газруудад шувууны хиймэл үүр суурилууллаа.

Хиймэл үүрэнд шувууд үүрлэхэд тодорхой хугацаа шаардагддаг тул уг ажлын үр дүнг ирэх хавраас харах боломжтой юм. Хээрийн махчин шувууд идэш тэжээл элбэг ч байгалийн үүрлэх байр ховор бол тэдгээрийн тоо толгой тогтвортой байх, өсөж үржих нөхцөл боломж хязгаарлагддаг. Мөн зарим төрлийн шувууд өөрөө үүр засдаггүй ба хад асга, модонд өөр төрлийн шувуудын зассан бэлэн үүрэнд үүрлэдэг. Ийм төрлийн шувууд сүүлийн жилүүдэд өндөр хүчдэл дээр сууж, цахилгаанд цохиулан эрсдэх тохиолдол манай орны хэмжээнд ихээр гарах болсон. Тиймээс идэш тэжээл элбэг газар нь хиймэл үүр хийх нь шонхор, сар зэрэг хээрийн махчин шувуудын өсөлтөд ихээхэн



ач холбогдолтой. Мөн түүнчлэн бэлчээрийн хөнөөлт мэрэгчдийн зохистой тоо толгойг хадгалахад махчин шувуудад зориулсан хиймэл үүр чухал хэрэгцээтэй юм.

Зэрлэг амьтдыг хамгаалав

Говийн бүс нутгаар энэ жилийн өвөл цас бага орсны улмаас цасан бүрхэвчийн хэмжээ багасч зэрлэг амьтад ангах, усгүйдэх байдалд хүрсэн. Үүний улмаас малчдын худаг, гүний худаг руу зэрлэг амьтад орж ирэх тохиолдол ихэссэн. Хээрийн ажиглалтаар Цэций хайрхан ууланд 13 янгир ямаа ажиглагдсан ба үнэг, хярсний мөр байсан нь тухайн газарт үнэг, хярс, бор туулай зэрэг амьтад байгааг илэрхийлж байна. Иймээс эдгээр амьтдыг усаар хангах зорилгоор уулын арын сүүдэр хэсэг, янгирын идээшилдэг, байрладаг хэсгүүдэд мөс, өвс тавьж өгөх ажлыг компаниас зохион байгуулсан. Зэрлэг амьтад нэмэгдлээр ус, өвс тэжээл тавьж байгаа нь зэрлэг амьтдыг өлдөх, хоол тэжээлийн хомсдолд орохоос урьдчилан сэргийлэх зорилготой байлаа.

Заган ойг тэлж ургуулж байна

Монгол орны говь, цөл нутагт ойн санг бүрдүүлдэг мод бол заг бөгөөд заган ой нь хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, элсний нүүлт хөдөлгөөнийг тогтворжуулахаас гадна тухайн нутгийн мал сүрэг, ан амьтан идээших, амьдрах аятай орчин нөхцлийг



бүрдүүлдгээрээ экологийн өндөр ач холбогдолтой юм. Өмнөговь аймгийн заг бүхий газар нутагт 2011 онд заган ой зохион байгуулах ажлыг гүйцэтгэж Цогтцэций сумын нутаг дахь заган ойн талбайг нарийвчлан судалсан байдаг. Тус судалгаагаар Цогтцэций сумын төвөөс зүүн хойд зүгт 42км зайд Наймдайн хөндийн Боронхойн хоолойд 3 га талбайд шар мод, нохойн шээрэн зэрэг бут сөөгтэй холимог байдлаар тармаг заган ой тархан ургасан ба тармаг заган ойн дундаж нас 20 жил, голч нь 8см, дундаж өндөр нь 1.2м ба 0.2 өтгөрөлтэй, чулуут цөлийн хэв шинж бүхий тармаг ой байгаа, бут сөөгний нягтшил нь 3 буюу шигүү байна гэдгийг тогтоосон.

2014 онд уг байгалийн заган ой ургасан газрын талбайг өргөжүүлэн, нэмж зургаан га талбайг сонгон авч, загаар ойжуулалт хийх ажлыг амжилттай зохион байгууллаа. Энэ ажлын хүрээнд өнгөрөгч оны 6-р сард 7500 орчим загийн тарьцаар ойжуулалт хийсэн бөгөөд ойжуулалтанд ашигласан хоёр настай суулгацыг компанийн байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайд үрээр ургуулж бойжуулсан. Тус оныхоо намар буюу аравдугаар сард ойжуулалт хийсэн талбайн амьдралтын хувь тогтоох тооллогоор амьдралтын хувь 65 хувьтай тоологдсон нь говийн нөхцөлд хангалттай үзүүлэлт юм. Тиймээс ирэх жил тус талбайд нөхөн тарилт хийх, ойжуулах талбайг тэлэх зэрэг ажлуудыг төлөвлөж байна.

Компанийн зүгээс заган төглийг амжилттай тарьж ургуулах магадлалыг нэмэгдүүлэхийн тулд зориулалтын усалгааны шийдэл, мал амьтан орохоос сэргийлсэн хашаа, байгаль орчинд ээлтэй, усны чийг баригч полимер зэргийг ашиглаж байна.

■ УСНЫ ЗОХИСТОЙ ХЭРЭГЛЭЭ

Ухаа Худаг уурхайн цогцолборын үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг бөгөөд дэвшилтэт системийг бий болгох ажил 2008 оны 1-р сараас эхэлж улмаар 2011 оны 6-р сард ашиглалтад орсон. Ингэснээр уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангаад зогсохгүй Өмнөговь аймгийн Цогтцэций сумын иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, цэвэршүүлсэн ундны усаар хангаж байна. Ус хангамжийн систем нь 56,000м³ багтаамжтай усан сан, насос станц болон иж бүрэн автомат хяналтын систем гээд технологийн онцлог шийдэл бүхий хэсгүүдээс бүрдэл болдог. Усан сангаас ус шүүрч алдагдахаас сэргийлж ёроолыг бүрэн доторлосон бөгөөд ууршилтаас хамгаалах битүү хучилттай хийсэн.

Мөн тус компанийн усны чанарын лабораторийн үйл ажиллагаа, техник технологи, мэргэжилтнүүдийн чадавхи холбогдох шаардлагуудыг бүрэн хангасан учир Монгол Улсын стандарт хэмжил зүйн газраас тус лабораторит итгэмжлэл олгосон бөгөөд цаашид уг лабораторийн тусламжтайгаар дотоодын хяналтыг өндөр түвшинд, стандартын шаардлага хангасан байдлаар явуулах боломж бүрдсэнээрээ өндөр ач холбогдолтой юм.

Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэр

Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийн технологийн гол ажиллагаа нь Австри Улсын Андриц компанид үйлдвэрлэсэн CPF-3000 маркын найман ширхэг усгүйжүүлэх машинд суурилдаг бөгөөд тус үйлдвэр нь Нүүрс баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаатай уялдан 24 цагаар ажилладаг.

Уг үйлдвэр нь хоногт 16500м³ хаягдлын холимгийг хүлээн авч, 11,550 м³ ус, 4,950м³ хуурай хаягдал болгон шүүх хүчин чадалтай.

Шүүгдсэн усыг технологийн шугаманд эргүүлэн ашиглаж, хуурай хаягдлыг төлөвлөсөн ачилтын хэсгийн конвейерээр дамжуулан тээврийн хэрэгслээр зөөдөг.

Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг барьж байгуулснаар үйлдвэрийн хаягдлыг маш богино хугацаанд усгүй болгож, эргүүлэн Нүүрс баяжуулах үйлдвэрийн хэрэгцээний усыг нөхдөг тул үйлдвэрлэлд ашиглах усны хэмжээ өмнөхөөс дор хаяж 60–70 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.



■ АГААРЫН ЧАНАР, ТООСЖИЛТ

2014 онд Ухаа Худаг төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй агаар бохирдуулах хийнүүдийг тодорхойлох, үүсч болох эх үүсвэрүүдийг байнгын хяналтанд авах, тэдгээрийн хэмжээг стандарттай харьцуулж үзэх, зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн бол бууруулах арга хэмжээ авах зэрэг чиглэлүүдэд анхаарч ажиллалаа.

Тоос дарах төхөөрөмж санаачлав

Нүүрс баяжуулах үйлдвэрээс үүсэх тоосжилтыг бууруулах ажлын хүрээнд түүхий нүүрсний тэжээлийн хэсэгт зориулж усыг мананцаржуулж, цас үүсгэж цацах төхөөрөмжийг тус үйлдвэрийн засварын хэсэг зохион бүтээсэн бөгөөд туршилтын үр дүнгээр уг төхөөрөмжийг ашиглан усан мананцар ба хиймэл цас үүсгэж болох нь нотлогдсон тул түүний хүчин чадлыг нэмэгдүүлэх, улмаар үйлдвэрийн тоос үүсгэдэг цэгүүд дээр суурилуулж ашиглахаар төлөвлөж байна.

Нарийн ширхэгтэй нүүрсийг эргүүлэн ашиглаж байна

Үйлдвэрийн технологийн горим алдагдах, эвдрэл гэмтэл гарах, шугам хоолой бөглөрөх, цоорох, хөлдөх, конвейерын тууз гэмтэх гэх мэт асуудал гарсан үед үйлдвэрийн ойр орчимд нүүрсний асгаралт үүсдэг. Уг асгаралтууд нь тоосжилтын нэг эх үүсвэр болж байсан тул асгаралтаас үүссэн хаягдлыг үйлдвэрт

тэжээл болгон өгөх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр гадаа задгай талбайгаас тоосжилт үүсэх нөхцлийг бууруулсан. Хаягдал нүүрсийг үйлдвэрийн тэжээл болгон боловсруулснаар тоосжилтыг бууруулахаас гадна үйлдвэрийн бүтээгдэхүүний алдагдлыг багасгах ач холбогдолтой юм.

Салаа замуудыг хааж, хяналт тавьж байна

2013 онд төслийн талбай доторхи бүх техногени гаралтай хөрсний эвдрэлд орсон газрын судалгаа, салаа замын бүртгэл хийгдсэн ба уг судалгааны үр дүнд 2014 онд шороон замууд дээр хяналт тавьж ажилласан. Шаардлагагүй шороон замуудыг хааж, замын нэгдсэн сүлжээг ашигласнаар хөрсний элэгдэл эвдрэл, тоосжилтыг багасгах зэрэг байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаас гадна замын хөдөлгөөний болзошгүй ослоос сэргийлэх ач холбогдолтой юм. Мөн ажилчдын хотхоноос төслийн талбай хүртэлх хатуу хучилттай авто замаас салаалж гарсан замуудыг хааж замын хажуугийн шуудууг гүнзгийрүүлж, хатуу хучилттай замд олон газраар нийлэх, түүнээс салж гарах нөхцлийг хязгаарлах арга хэмжээ авлаа

■ ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Төслийн үйл ажиллагаанаас үүдэлтэй үүсч буй нийт хог хаягдлын байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөллийг нь бууруулах үүднээс системтэйгээр цуглуулж, зайлуулах нь хариуцлагатай уул уурхайн чухал зарчмуудын нэг юм.

Үйл ажиллагаа өргөжихийн хирээр хог хаягдлын үүсэх хэмжээ нэмэгдэж, цаг тухайд нь зохистойгоор зайлуулаагүйн улмаас орчны бохирдол ихсэх эрсдэл байдаг. Иймд байгаль орчны багийн зүгээс хог хаягдлын үүсэлтийг бууруулах, дахин ашиглах, дахин боловсруулах, хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, зайлуулах ажлыг системтэйгээр зохион байгуулж хог хаягдлын менежмент төлөвлөгөөг улам боловсронгуй болгоход анхааран ажиллаж байна.

Хогийн цэг ба ангилан ялгалт

Энержи Ресурс компанийн зүгээс хог хаягдлын менежментийн олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн “3R+R” системийг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд тухайн хаягдлын дахин боловсруулалт ба дахин ашиглалтын арга технологийн сонголтоос шалтгаалан ангилан ялгалтыг хийж байна. Хог хаягдлын ангилан ялгалтыг хийхдээ хогийн савыг өнгөөр ялган, кодчилох системийг нэвтрүүлж, хаягжуулалт хийдэг. Хатуу хог хаягдлын цэг нь ангилан ялгалтын хэсэг, дахин ашиглах хаягдал, дахин боловсруулах хаягдлын хэсэг болон шатаах зуух, устгах хэсгүүдээс бүрддэг. 2014 онд төслийн хүрээнд нийт хатуу хаягдлын хэмжээ 12261.4м³ бөгөөд сард 1362.4м³ үүссэн үзүүлэлттэй байна. Нийт хатуу хог хаягдлын 41 орчим хувь нь дахин боловсруулах болон ашиглах хаягдал байна.



Хог хаягдал дахин ашиглах цех

Төслийн үйл ажиллагаанаас үүсч байгаа дахин ашиглагдах буюу дахин боловсруулагдах боломжтой хог хаягдлыг бүтээгдэхүүн болгож, байгаль орчинд хаягдах хогны хэмжээг бууруулах үүднээс дахиврын цехийн үйл ажиллагааг эхлүүлсэн. Уг цехэд дахин ашиглагдах/боловсруулагдах хог хаягдал буюу хоёрдогч түүхий эдийг ашиглан блок, хогийн сав, сандал, дааман хаалга, сейф, дугуйны зогсоол, малын нэмнээ, гэрийн хаяавч, ачааны бүтээлэг зэрэг 10 гаруй нэр төрлийн ахуйн хэрэгцээний бүтээгдэхүүн үйлдвэрлэн зах зээлд нийлүүлж байна. Хог хаягдлын 41 хувийг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх ба дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлэх байдлаар хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж хүрээлэн буй орчинд устгах хог хаягдлын хэмжээг тэр хэмжээгээр багасгаж чадсан бөгөөд цаашид хог хаягдал дахин

ашиглах, цехэд үйлдвэрлэх бүтээгдэхүүний төрөл зүйл, тоо хэмжээг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Хог хаягдлаар орчноо тохижуулж байна

Ухаа Худаг уурхайн засварын төвийн хамт олон ажлын орчноо тохижуулж, засварын төвийн ойр орчимд ногоон байгууламж бий болгох ажлыг санаачилж, засварын төвөө тойруулан нийт 250 мод суулгаж, төрөл бүрийн цэцэг, ногоо тарьж, энэхүү ногоон байгууламжаа хамгаалах үүднээс хайс, амралтын талбай, сүүдрэвч, сандал зэргийг зөвхөн хаягдал материал ашиглан өөрсдийн гараар урлажээ. Тухайлбал засварын тоног төхөөрөмжийн угсралтаас үлдсэн хайрцаг, бэхэлгээ зэргийг задалж, модон материал болгон ашигласан бол хаягдал төмөр торх ашиглан амралтын сандал хийсэн байна.



Хог хаягдлын цэвэрлэгээ

Тайлант онд төслийн хүрээнд их цэвэрлэгээг нийт дөрвөн удаа зохион байгуулж, 300 гаруй ажилтан давхардсан тоогоор 820 гаруй га талбайн хогийг цэвэрлэлээ. Мөн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Засаг даргын “Нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай” захирамжийн дагуу Энержи Ресурс болон Паблик сервис ХХК-ийн ажилтнууд хамтран “Цэций” хороолол, Галерей кэмп, Мөрөөдөл сургууль, Уурхайчин хороолол, уурхай хүртэлх зам дагуу нийт 12 куб метр хог цэвэрлэж, сумын хог хаягдлын цэгт хүргэсэн.



■ БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Ухаа Худаг төслийн үйл ажиллагаа эхэлсэн үеэс эхлэн байгаль орчны хяналт шинжилгээний ажлууд тасралтгүй хийгдэж ирсэн. Байгаль орчны хяналт шинжилгээний ажлын гол зорилго нь уурхайн төслийн болзошгүй сөрөг нөлөөллийн хэмжээ, цар хүрээг бүрэн тодорхойлж хянах, улмаар тухайн сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх, гарсан үр дүнг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг тодорхойлоход оршдог.

Гадаад орчин гэдэгт олон зүйл багтдаг учир Ухаа Худаг төслийн хамрах хүрээнд газрын доорх усны, агаарын чанарын буюу орчны тоосжилтийн, дуу чимээ, ургамалжилт, амьтны аймгийн, хөрсний элэгдэл, эвдрэл бохирдлын, цаг уур, ууршилтын зэрэг чиглэлүүдээр хяналт шинжилгээний ажлыг явуулж, нийт 240 орчим цэгт байнгын хэмжилт хийдэг байна. Ийнхүү хэмжилт судалгаа, дээжлэлт, мэдээлэл боловсруулалтын ажлууд тогтмол хийгддэг тул гарсан үр дүн, дээжүүдийг дотоодын болон гадаад орнуудын итгэмжлэгдсэн лабораториудад хүргүүлж хамтран ажилладаг.

Хээрийн хэмжилт судалгаанд орчин үеийн, өндөр нарийвчлалтай багаж төхөөрөмжүүдийг ашигладаг. Мөн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор орон нутгийн иргэдийг байгаль орчны хяналт шинжилгээ, хээрийн хэмжилт судалгаанд оролцуулдаг бөгөөд одоогоор орон нутгийн 100 гаруй иргэн уг ажилд хамрагджээ.



Байгаль орчны багц хуулийн шинэчлэлийн хүрээнд бий болсон байгаль орчны хөндлөнгийн – төлөвлөгөөт аудитыг эрх бүхий мэргэжлийн байгууллагатай экологийн хариуцлагын гэрээ байгуулан төслийн үйл ажиллагааны бүх хүрээг хамруулан хийлгэсэн бөгөөд хөндлөнгийн аудитийн багаас компанийн байгаль орчинд ээлтэй анхдагч тэргүүн туршлагаудыг өндрөөр үнэлсэн.

Хяналтын ажилд нутгийн иргэд оролцож байна

Тус компаниас байгаль орчны мониторинг хийж гүйцэтгэхдээ нутгийн иргэд болон мэргэжлийн

хүмүүсийг байлцуулж, хөндлөнгийн хяналт тавиулах ажлыг тогтмол зохион байгуулдаг. Баруун наран уурхай орчим орчны хяналт шинжилгээний ажил хийхдээ Их бууц болон Богвайн шанд худгаас ус ашигладаг малчдын төлөөлөл болгож 7 малчныг оролцуулаа. Малчдын зүгээс ус, тоосны хэмжилтэнд иргэдийг оролцуулж, мэдээллээр хангаж байгаад талархалтай байгаагаа илэрхийлээд цаашид өөрсдөө усны ундаргыг хэмждэг боломжтой болох, худга ус шинээр гаргуулах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ.

Байгаль орчны сургалт, сурталчилгаа



Иргэдийн байгаль орчинтой харьцах зөв хандлагыг төлөвшүүлэх, компанийн байгаль орчны дотоод журмын талаар мэдээлэл өгөх зорилгоор олон нийт, компанийн ажиллагсадд байгаль орчны ерөнхий сургалт болон нарийвчилсан зааварчилгааг тогтмол өгсөөр ирсэн. Энэ хүрээнд компанийн байгаль орчны бодлого, дотоод журам, хог хаягдлын сөрөг нөлөө, ангилан ялгах ач холбогдол, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, урьдчилан сэргийлэх боломжууд болон орчны эрүүл ахуй, байгалийн нөөцийн зохистой хэрэглээ зэрэг сэдвүүдээр оролцогчдод мэдээлэл хүргэдэг.

2014 онд байгаль орчны ерөнхий ба давтан зааварчилгаанд давхардсан тоогоор нийт 3219 ажилтан хамрагдсан. Мөн бүх нийтийн экологийн боловсрол олгох үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Цогтцэций сумын Мөрөөдөл дунд сургуулийн сурагчдад усны нөөц, түүнийг зүй зохистой хэрэглэх ач холбогдлын талаар мэдээл сургалт хийж, тэдний мэдлэгийг сорих “АХА” уралдаант тэмцээн зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээнд нийт 120 сурагч оролцож, мэдлэг ур чадвараараа өрсөлдлөө.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

■ БОДЛОГО, ЧИГ БАРИМЖАА

Компанийн ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг чухалчлан үзэж, эрүүл аюулгүй ажиллах орчин бий болгох нь бидний эрхэм зорилго билээ. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажилтан ажиллагсдаа эрүүл аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцож буй бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишгийн дагуу ханган ажиллахыг эрмэлздэг.

Хайгуул, ашиглалт, тээвэрлэлт үйлдвэрлэл болон нөхөн сэргээлтийн бүхий л үе шатанд Энержи Ресурс ХХК нь ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний чухал ач холбогдол өгч “АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАСНЫ ДАРАА АЖЛАА ЭХЭЛБЭ” хэмээх уриаг эрхэмлэн ажилладаг. Тус компанийн Хөдөлмөрийн Аюулгүй Байдалын нэгж нь Ухаа Худаг төслийн хүрээнд Хөдөлмөрийн Аюулгүй Байдал Эрүүл Ахуйн Удирдлагын Тогтолцоо OHSAS 18001: 2007-г нэвтрүүлэн ажиллаж байна.

ХАБ-ын гол үзүүлэлтүүд

ҮЗҮҮЛЭЛТ	2012	2013	2014
Нийт ажилласан хүн цаг	8,380,412	8,154,576	5,643,141
Эндэгдэл	1	1	2
Нийт гэмтлийн давтамж	3.94	3.56	5.32
Хугацаа алдсан гэмтлийн давтамж (LTIFs)	0.72	1.23	1.24
Хууль, журамд нийцэж ажилласан байдал	94%	шалгаагүй	87%
Алдсан хоногийн давтамж (ажиллаагүй хоног/ажилласан цаг)	0.000019	0.000028	0.000158
ХАБ-ын сургалт, зааварчилгаа	6,783	12,881	12,681

■ СУРГАЛТ, ЗААВАРЧИЛГАА

Ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлох, нийт ажиллагсдад ХАБ, эрүүл ахуйн сургалтыг зохион байгуулах, ажлын байрны үзлэгийг тогтмол хийж зөрчлийг арилгуулах, ослын судалгааг хийх гэх мэт ажлууд тогтмол хийгддэг. 2014 онд нийт 94 ажлын байрны аюулгүйн үзлэг зохион байгуулж илэрсэн дутагдал зөрчлийг арилгах шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилласан. Мөн ХАБ, эрүүл ахуйн бодлого, Ухаа Худаг төслийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн систем, хамгаалах хэрэгслийг ашиглах, цахилгааны аюулгүй ажиллагаа, онцгой нөхцөл байдлын журмууд, ослын менежмент, эрсдлийн менежмент болон анхны тусламжийн сургалтууд тогтмол хийгддэг.

Аюулгүй ажиллагааны аяныг санаачилгаа

2014 онд уурхайн нийт ажилтнуудыг хамруулсан аюулгүй байдлаа өөрсдөө хянах, урьдчилан сэргийлэх зорилготой “Super Crew Safety” буюу “Аюулгүй ажиллагааны баг” санаачлагыг нэг жилийн хугацаанд өрнүүлж, улирал бүр шилдгүүдийг шалгаруулсан. Энэхүү ажлын хүрээнд ээлж солилцохын өмнө ээлжийн мастерууд ажлаа тайлагнахын зэрэгцээ өдөр бүр аюулгүй ажиллагаа хэрхэн хангагдсан талаарх мэдээллийг самбарт тэмдэглэж, аюулгүй ажиллагаа нь нэг хүний биш, нийт багийн гишүүдийн үүрэг болохыг ил тодоор мэдээлж хэвшүүлсэн.

Санаачлагын үр дүнд аянд хамрагдсан бүх ажиллагсад аюулгүй ажиллах дадлагыг хэвшүүлж сурсан хэмээн уг ажлыг зохион байгуулагчид дүгнэлээ.

БИДНИЙ АМЖИЛТ

“Мөнгөн меркури” цом авлаа

Энержи Ресурс компани нь Монголын Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд (МҮХАҮТ) жил бүр тодруулдаг улсын TOP 10 аж ахуйн нэгжийн нэгээр сүүлийн зургаан жил дараалан шалгарсан бөгөөд 2014 онд “Мөнгөн меркури” цомыг авлаа. Жил тутам шилдэг бизнес эрхлэгчдийг тодруулдаг уг арга хэмжээний шалгаруулалтыг хийхдээ тухайн компанийн төлсөн татварын дүн, хөрөнгө оруулалтын хэмжээ, нэвтрүүлсэн техник технологи, нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа зэргийг харгалзан үздэг.

Топ 150 аж ахуйн нэгжийн дөрөвт шалгарлаа

Мөн өнгөрөгч онд улс орны эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулж буй, үндэсний шилдэг бизнесүүдийг нэрлэдэг ТОП 150 аж ахуйн нэгжийн шалгаруулалтад гурав дахь жилдээ амжилттай оролцож, улсдаа тэргүүлэгч компаниудын дөрөвт жагслаа. Монгол Улсын Засгийн газар ба МҮХАҮТ хамтран жил бүр зохион байгуулдаг уг шалгаруулалтын

тэргүүлэгчдийн эгнээнд төрийн өмчит Эрдэнэт үйлдвэр, М-Си-Эс групп, Петровис ХХК, Энержи Ресурс болон Номин Холдинг компаниуд тус тус багтжээ.

Уул уурхайн салбарын шилдэг технологиор нэрлэв

Уул уурхайн салбарын оны шилдгийг шалгаруулдаг Mining Journal Awards шагнал гардуулах ёслолын “Шилдэг технологи” номинацид Ухаа Худагийн Нүүрс баяжуулах үйлдвэрт ашиглагдаж буй Австрийн алдарт Андриц компанийн үйлдвэрлэлийн хаягдлыг усгүйжүүлэх технологи шалгарсан байна.

Энэхүү технологи нь үйлдвэрлэлийн усны хэрэглээг өмнөхөөс 60–70 хувь бууруулж байгаагаараа Монголд анхдагч шинэлэг бөгөөд өндөр ач холбогдолтой юм. Уул уурхай эдийн засгийн тэргүүлэгч салбар гэж тооцогдож буй манай улсын хувьд, тэр дундаа усны нөөцөөр хомс говь нутагт энэхүү технологийг түгээн дэлгэрүүлж, өргөнөөр ашиглах шаардлагатайг шалгаруулалтын шүүгчдийн зөвлөл онцолсон байна.

Олон улсын зах зээлд нүүрсний нийлүүлэлт эрэлтээсээ давсны улмаас 2012 оноос хойш нүүрсний үнэ тасралтгүй унаж, өнөөдрийг хүртэл зах зээлийн байдал таагүй байсаар байна.

Сүүлийн жилүүдэд салбарын нөхцөл байдал ийнхүү хүнд байсан хэдий ч Энержи Ресурс компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулж, экспортоо үргэлжлүүлэн 2014 онд 74 тэрбум төгрөгийн татвар улсын төсөвт төвлөрүүлээ.

Компанийн зүгээс ажиллагсдынхаа ажлын байрыг аль болох хадгалах, тэдний нийгмийн баталгааг хангах тал дээр анхаарч, бүтээмжээ нэмэгдүүлэх, зардал бууруулах, үйл ажиллагааны оновчтой зохион байгуулалтад шилжих зэргээр дотоод нөөц бололцоогоо дайчлан ажиллаж өөрсдөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Бид олон улсын санхүүгийн зах зээлд өөрийн хувьцаа, бондыг гаргасан үндэсний цорын ганц аж ахуйн нэгжийн хувьд дэлхийн олон зуун мянган хөрөнгө оруулагчдын итгэн төвлөрүүлсэн санхүүгийн эх үүсвэрийг Ухаа Худагийн бодит бүтээн байгуулалт, үйл хэрэгт зарцуулан үр шимийг нь Монголынхоо хөрсөнд шингээсэн билээ. Монгол залуусын сэтгэл, зүтгэл шингэсэн бүтээн байгуулалт, үйлдвэр, холбогдох дэд бүтцийнхээ үр өгөөжийг гаргахын төлөө бид улам бүр хичээн ажиллах болно.

Энержи Ресурс компани нь цаашид орон нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэд, малчид, бизнес эрхлэгчид зэрэг оролцогч талуудтай хамтран ажиллаж, орон нутаг болон улс орныхоо бүтээн байгуулалт, хөгжил цэцэглэлтэнд хувь нэмрээ оруулан ажиллаж, олон улсын зах зээлд Монголын брэнд болсон нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн түвшний үйлдвэрлэгч компани байх болно.



Хаяг: Централ Тауэр, 16 давхар
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар хот 14200
Монгол Улс

Утас: + (976)-70122279, 70132279
Факс: + (976)-11-322279
Цахим шуудан: contact@mmc.mn
Цахим хаяг: www.energyresources.mn

Ухаа Худаг Уурхайчдын хотхон
Ухаа Худаг, Цогтцэций сум
Өмнөговь аймаг 46040
Монгол Улс
Утас: +(976)-77202279